



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

Байгууллагын нэр

Газар зохион байгуулалт, геодези, зураг
зүйн газар

Нэгжийн нэр:

Суурь судалгаа, мониторингийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Хот тосгон, бусад суурины газрын
мониторингийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын хууль болон Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хот суурин, зам, шугам сүлжээний газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг зохион байгуулах, мониторингийн сүлжээг өргөжүүлэх, байнгын ажиллагааг хангах, хяналт тавих, холбогдох мэдээллийн санг улсын хэмжээнд байгуулах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Монгол Улсын хууль болон Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын стратеги төлөвлөгөө, байгууллагын стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт тусгагдсан чиг үүрэг, газрын талаар төрөөс баримтлах бодлого, холбогдох хууль тогтоомж болон тэдгээрт нийцүүлэн гаргах хэм хэмжээний эрх зүйн баримт бичгийг боловсруулах;

2.Хот тосгон, бусад суурины газар, зам шугам сүлжээний газрыг үр ашигтай, зохистой ашиглах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг зохион байгуулах, мониторингийн цэгийг өтгөрүүлэх, шинээр цэг тогтоох, хөрсний бохирдлын чиглэлээр нэгдсэн дүгнэлт зөвлөмж гаргах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

3.Хот тосгон, бусад суурины газар, зам шугам сүлжээний газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны зардлыг улсын төсөвт тусгуулах, хот тосгоны мониторингийн сүлжээний цэгийг өтгөрүүлэх, нэгдмэл сангийн хот тосгон, бусад суурины ангиллын газар ашиглалтын төрлөөр төлөв байдлын өөрчлөлтийг лавлагаа түвшинтэй харьцуулан дүгнэлт, зөвлөмж гаргах, мэдээллийн санг хөтлөх, баяжуулах, олон нийтэд үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

4.Газрын суурь, судалгаа мониторингийн чиглэлээр мэргэжлийн боловсон хүчний сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлох, хүний нөөцийг мэргэшүүлэх, чадавхжуулах, давтан сургах, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;

5.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Монгол Улсын хууль болон Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан холбогдох чиг үүрэг, заалтыг хэрэгжүүлэх, тайлагнах;	Холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байх;	Г
	2.Салбарын болон байгууллагын стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт тусгагдсан чиг үүргийн хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааны дунд болон богино хугацааны төлөвлөлтөд хариуцсан чиглэлээр санал боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах;	Байгууллагын стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, байгууллагын дунд болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт хангагдсан байх;	Г
	3.Хот тосгон, бусад суурины газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, мониторингийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар, арга зүй, аргачлал, дүрэм, журам, норм, стандарт, ажлын үнэлгээг шинэчлэх,	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх;	



	боловсронгуй болгох санал боловсруулах, хэлэлцүүлж, батлуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах;		
	4.Хот тосгон, бусад суурины газар, зам шугам сүлжээний газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны талаарх судалгаа, шинжилгээ хийх, иновцад суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх;	Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан, судалгаа, дүгнэлт бодитой хийгдсэн байх;	Г
	5.Хот тосгон, бусад суурины газар, зам шугам сүлжээний газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, нөхөн сэргээлтийн чиглэлээр хийгдэх төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих.	Судалгаа, дүгнэлт бодитой хийгдсэн байх.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хот тосгон, бусад суурины газар, зам шугам сүлжээний газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг зохион байгуулах, хариуцсан асуудлын хүрээнд мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, дүгнэх, мэдээллийн санг хөтлөх;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх;	Г
	2.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн тайлан, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт суурь, судалгаа, мониторингийн чиглэлээр хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх;	Г
	3.Хот тосгон, бусад суурины газар, зам шугам сүлжээний газар, нийтийн эдэлбэр газруудад мониторингийн байнгын ажиглалтын талбар, мониторингийн цэгийн тоог нэмэгдүүлэх, хөрсний хүнд металлын бохирдол, доройтолд өртсөн газруудад мониторингийн судалгаа хийх, дүгнэлт зөвлөмж гаргах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх;	Г



	4.Уул уурхайн эдэлбэр газрын ашиглалт, төлөв байдлын өөрчлөлтийг тодорхойлох, мониторингийн цэгийг байгуулах, хөрсний хүнд металлын бохирдол болон эрүүл ахуй, физик, хими, биологийн бохирдолд дүн шинжилгээ хийх, дүгнэлт зөвлөмж гаргах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх;	Г
	5.Амралт, аялал жуулчлалын газруудын төлөв байдлын өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, хөрсний хүнд металлын бохирдол болон эрүүл ахуй, физик, хими, биологийн бохирдолд дүн шинжилгээ хийх, үнэлэх.	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Хот тосгон, бусад суурины газар, зам шугам сүлжээний газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, мониторингийн улсын сүлжээг байгуулах, холбогдох мэдээллийн санг байгуулан хэвийн үйл ажиллагааг хангах;	Тооцоо, судалгааг нь үнэн зөв гаргасан байх;	Г
	2.Хот тосгон, бусад суурины газар, зам шугам сүлжээний газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, мониторингийн цэгт хийгдэх зардлын тооцоог гаргах, холбогдох төсөвт суулгах ажлыг зохион байгуулах, харьцуулалт хийх, хяналт тавих, тайлагнах;	Орон зайн мэдээллийн сангийн шаардлагыг хангасан байх;	Г
	3.Хот тосгон, бусад суурины газар, зам шугам сүлжээний газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийг тогтоож, үр дүнг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах;	Үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирсан байх;	Г
	4.Хот суурин, зам, шугам сүлжээний газрын төлөв байдал, чанарын мониторингийн ажилд агаар, сансрын зургийг ашиглах боломжийг бүрдүүлэх, боловсруулах, хэрэглээнд нэвтрүүлэх;	Зайнаас тандан судлалын үйл ажиллагаа нэвтрэсэн байх;	Г
	5.Хот тосгон, бусад суурины газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, мониторингийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, лавлагаа түвшинтэй харьцуулан дүгнэлт гаргах, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах;	Доройтол, талхлагдал, бохирдолтод өртсөн газар нөхөн сэргээгдсэн байх;	Г



	6.Хот тосгон, бусад суурины газрын ангиллын газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, мониторингийн бүх төрлийн мэдээллээр олон нийтэд үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;	Үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирсан байх;	Г
	7.Холбогдох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага болон гадаад орны төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах, энэ чиглэлийн мэдээллээр хэрэглэгчдийг хангах.	Үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирсан байх.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	2.Хариуцсан асуудлын чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах, мэргэшүүлэх, давтан сургах ажлыг холбогдох байгууллага болон нэгжүүдтэй хамтран зохион байгуулах;	Мэргэжилтэн, албан хаагчдын ур чадвар нэмэгдсэн байх;	Г
	3.Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа болон бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах.	Мэргэжилтэн, албан хаагчдын ур чадвар нэмэгдсэн байх.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	1.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, дотоод ажлыг зохион байгуулах;	Холбогдох журамд нийцсэн байх;	Г
	2.Салбарын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцсан ажлын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлын тооцоо, төсөвт тусгуулах санал боловсруулж, нэгжийн даргад танилцуулан, хэрэгжилтийг хангах;	Холбогдох журамд нийцсэн байх;	Г
	3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, нэгжийн даргад танилцуулах, батлуулах;	Холбогдох журамд нийцсэн байх;	Г
	4.Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр нэгтгэж, нэгжийн даргад тайлагнах;	Холбогдох журамд нийцсэн байх;	Г
	5.Үнэлгээний хороо болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах;	Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байх;	Г
	6.Байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хурал, удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, цаг үеийн шаардлагаар гарсан	Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байх;	Г



	ажлуудыг тухай бүр зохицуулан зохион байгуулах, биелэлтийг хангаж, тайлагнах;		
	7.Байгууллагын дотоод дүрэм, журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллах, төрийн захиргааны манлайллыг хэрэгжүүлэх;	Дүрэм, журам ёс зүйн хэм хэмжээнд заасан манлайлал бий болсон байх;	Г
	8.Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр архивын хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хүлээлгэн өгөх;	Архивын ажлын үндсэн зааварт нийцсэн байх;	Г
	9.Байгууллагын болон нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаа, хурал, сургалт, олон нийтийн арга хэмжээнд оролцох.	Албан хаагчийн мэргэжилийн ур чадвар нэмэгдсэн байх.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	- Архитектур, хот төлөвлөлт (073101-073103); - дэлхий судлал (053201-053205, 053208); - хүрээлэн буй орчныг хамгаалах технологи (071201-071203).		
Мэргэшил	-		
Туршлага	- Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- Мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; - нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг нэгтгэн дүгнэх, санал зөвлөмж боловсруулах; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх, тоон судалгаанд үндэслэн харьцуулалт, шинжилгээ хийх; - тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдал, хувилбарыг тодорхойлох чадвартай байх; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - албан тушаалын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг боловсруулах;	



		- удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах; - хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, мэдээлэлтэй холбогдсон асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах; - бусад.
	Багаар ажиллах	- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих, үр дүнтэй өөрчлөлт, шинэтгэлийг дэмжин хэрэгжүүлдэг байх; - багаар ажиллах, багийн ажлын амжилтыг үнэлэх, дэмжих, үүрэг хариуцлага хүлээх чадвартай байх; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах, хөрвөх чадвартай байх; - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; - ёс зүй, хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд бусдыг үлгэрлэн манлайлах; - бусад.
	Бусад ур чадвар	- Хүний эрхийн стандартуудыг хэрэгжүүлэх; - англи хэл эсхүл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - ArcGIS, QGIS, Erdas imaging болон газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлалын програм хангамж ашиглаж өгөгдөлд дүн шинжилгээ хийх чадвартай байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Суурь судалгаа, мониторингийн хэлтсийн дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

-

Бусад харилцах субъект:

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс;
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн холбогдох албан тушаалтан;
- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:



<u>Албан тушаал:</u> АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА <i>Б.САНДУЙЖАВ</i> 2023 оны 08 дугаар сарын <i>28</i> ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 23 08 22 Дугаар: 367
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР Шийдвэрийн огноо: 2023 .08. 28 Дугаар: 67/139 (тамга/тэмдэг) ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА <i>М. Батсайхан</i> 2023 оны 08 дугаар сарын <i>28</i> ны өдөр	

